



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2019 оны 03 сарын 26 өдөр

Дугаар 01/39

Улаанбаатар хот

Төслийн зөвлөх хорооны бүрэлдэхүүн
батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 3.1.1 дахь үйл ажиллагаа болон Засгийн газрын 2017 оны 225 дугаар тогтоолоор баталсан “Орчны эрүүл мэнд” үндэсний хөтөлбөр (2017-2020 он)-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний Зорилт 1, 4-ийг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. “Эх, хүүхдийн эрүүл мэндэд үзүүлэх агаарын бохирдлын нөлөөллийг бууруулах нь” төслийн зөвлөх хорооны бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, “Орон нутгийн иргэдэд түшиглэсэн, уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй ус хангамж, ариун цэвэр, эрүүл ахуйн үйлчилгээ” төслийн зөвлөх хорооны бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар, “Эх, хүүхдийн эрүүл мэндэд үзүүлэх агаарын бохирдлын нөлөөллийг бууруулах нь” төслийн зөвлөх хорооны ажиллах журмыг гуравдугаар хавсралтаар, “Орон нутгийн иргэдэд түшиглэсэн, уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй ус хангамж, ариун цэвэр, эрүүл ахуйн үйлчилгээ” төслийн зөвлөх хорооны ажиллах журмыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. Зөвлөх хорооны үйл ажиллагааг зохион байгуулж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Зөвлөх хорооны дарга /Л.Бямбасүрэн/-д даалгасугай.



САЙД

Д.САРАНГЭРЭЛ

080567

Эрүүл мэндийн сайдын 2019 оны 03 сарын 26-ны өдрийн А/39 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



“Эх, хүүхдийн эрүүл мэндэд агаарын бохирдлын нөлөөг бууруулах нь” төслийн зөвлөх хорооны бүрэлдэхүүн

- Дарга: Эрүүл мэндийн дэд сайд
- Дэд дарга: НҮБ-ын Хүүхдийн Сангийн Суурин төлөөлөгч (зөвшилцсөнөөр)
- Гишүүд:
- Эрүүл мэндийн яамны Нийгмийн эрүүл мэндийн газрын дарга
 - Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн газрын дарга
 - Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга (зөвшилцсөнөөр)
 - Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга (зөвшилцсөнөөр)
 - Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Төрийн нарийн бичгийн дарга (зөвшилцсөнөөр)
 - Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга (зөвшилцсөнөөр)
 - Нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан төслүүдийн удирдагч, Нийслэлийн Засаг даргын орлогч (зөвшилцсөнөөр)
 - Баянзүрх дүүргийн Засаг дарга (зөвшилцсөнөөр)
 - Сонгинохайрхан дүүргийн Засаг дарга (зөвшилцсөнөөр)
 - Баянхонгор аймгийн Засаг дарга (зөвшилцсөнөөр)
 - Швейцарийн хөгжлийн агентлагийн Хамтын ажиллагааны захирал (зөвшилцсөнөөр)
- Нарийн бичгийн дарга: ЭМЯ-ны Орчны эрүүл мэндийн асуудал хариуцсан мэргэжилтэн
- НҮБ-ын Хүүхдийн сангийн Мэдлэг менежмент хариуцсан мэргэжилтэн (зөвшилцсөнөөр)

Эрүүл мэндийн сайдын 2019 оны 03 сарын 26-ны өдрийн 4/13.9 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

“Орон нутгийн иргэдэд түшиглэсэн, уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй ус хангамж, ариун цэвэр, эрүүл ахуйн үйлчилгээ” төслийн зөвлөх хорооны бүрэлдэхүүн

Дарга: Эрүүл мэндийн Дэд сайд

Дэд дарга: НҮБ-ын Хүүхдийн Сангийн Суурин төлөөлөгч (зөвшилцсөнөөр)

Гишүүд:

Эрүүл мэндийн яамны Нийгмийн эрүүл мэндийн газрын дарга

Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн газрын дарга

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Ерөнхий боловсролын бодлогын газрын дарга (зөвшилцсөнөөр)

Баянхонгор аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (зөвшилцсөнөөр)

Говь-Алтай аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (зөвшилцсөнөөр)


Завхан аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (зөвшилцсөнөөр)

БНСУ-ын Олон улсын хамтын ажиллагааны байгууллагын Монгол дахь төлөөлөгчийн газрын төлөөлөл (зөвшилцсөнөөр)

Нарийн бичгийн дарга: ЭМЯ-ны Орчны эрүүл мэндийн асуудал хариуцсан мэргэжилтэн

НҮБ-ын Хүүхдийн Сангийн Ус хангамж, ариун цэвэр, эрүүл ахуй хариуцсан мэргэжилтэн (зөвшилцсөнөөр)

Эрүүл мэндийн сайдын 2019 оны 0.3 сарын 26-ны өдрийн А/Б.9 дугаар тушаалын гуравдугаар хавсралт



“Эх, хүүхдийн эрүүл мэндэд агаарын бохирдлын нөлөөг бууруулах нь” төслийн зөвлөх хорооны ажиллах журам

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Швейцарын Хөгжлийн Агентлаг, НҮБ-ын Хүүхдийн сангийн хамтарсан санхүүжилттэй Улаанбаатар хотын Баянзүрх дүүрэг, Баянхонгор аймагт 2018 оны IV улирлаас 2022 оны III улирал хүртэл хэрэгжих “Эх, хүүхдийн эрүүл мэндэд агаарын бохирдлын нөлөөг бууруулах нь” төслийн зөвлөх хороо /цаашид “Зөвлөх хороо” гэх/-ны үйл ажиллагааг энэхүү журмаар зохицуулна.

1.2 Зөвлөх хороо нь “Эх, хүүхдийн эрүүл мэндэд агаарын бохирдлын нөлөөг бууруулах нь” төслийн үйл ажиллагааг зохицуулах, хэрэгжүүлэх арга хэмжээний талаар зөвлөмж гарган, санхүүжүүлэгч талд дэмжлэг үзүүлэх орон тооны бус зөвлөх хороо мөн.

1.3 Зөвлөх хороо нь Эрүүл мэндийн салбарт хэрэгжиж буй эрх зүйн баримт бичиг, бусад хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгоно.

Хоёр. Зөвлөх хорооны бүтэц, үйл ажиллагааны зохион байгуулалт

2.1 Зөвлөх хороо нь дарга, дэд дарга, нарийн бичгийн дарга болон гишүүдээс бүрдэнэ.

2.2 Зөвлөх хорооны ажлын албаны үүргийг НҮБ-ын Хүүхдийн сан гүйцэтгэнэ.

2.3 Зөвлөх хорооны үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь зөвлөлийн хуралдаан байх ба хуралдааныг Зөвлөх хорооны дарга, түүний эзгүйд дэд дарга зарлан хуралдуулна.

2.4 Зөвлөх хорооны хуралдаан гишүүдийн ердийн олонхийн оролцсоноор хүчин төгөлдөр тооцогдож, асуудлыг хуралдаанд оролцогсдын олонхийн саналаар шийдвэрлэж, дүгнэлт зөвлөмж гаргана. Санал тэнцсэн тохиолдолд асуудлыг хуралдаан даргалагчийн саналаар шийдвэрлэнэ.

2.5 Зөвлөх хорооны гишүүн хүндэтгэх шалтгаангүйгээр хуралдаанд ирэхгүй тохиолдолд шалтгаанаа Зөвлөх хорооны дарга, дэд дарга, нарийн бичгийн дарга нарт хуралдаан болохоос 3 хоногийн өмнө мэдэгдэж, хэлэлцэх асуудалтай холбоотой саналаа ирүүлнэ.

2.6 Зөвлөх хорооны даргын эзгүйд дэд дарга түүнийг орлон ажиллана.

2.7 Зөвлөх хорооны гишүүний эзгүйд түүнийг орлуулахгүй.

2.8 Тухайн хэлэлцэж буй асуудалтай холбоотой ашиг сонирхлын зөрчил үүсэж болзошгүй нөхцөлд хамаарал бүхий гишүүнийг уг асуудлыг хэлэлцэхэд оролцохгүй.

Гурав. Зөвлөх хорооны даргын чиг үүрэг

3.1 Зөвлөх хорооны хуралдааныг жилд хоёроос доошгүй удаа зарлан хуралдуулж, хуралдааныг удирдах.

3.2 Зөвлөх хорооны хуралдааны төлөвлөгөө гаргах.

3.3 Хуралдаанаас гарсан шийдвэрийг тэмдэглэлээр баталгаажуулж, шаардлагатай гэж үзсэн зарим асуудлыг Эрүүл мэндийн яамны Удирдлагын зөвлөлийн хуралд хэлэлцүүлэн чиглэл өгөх.

3.4 Гишүүдэд үүрэг даалгавар өгч, биелэлтэд нь хяналт тавих ба явцын талаар гишүүдэд мэдэгдэх.

Дөрөв. Нарийн бичгийн даргын чиг үүрэг

4.1 Хуралдаанаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг Эрүүл мэндийн яамны Нийгмийн эрүүл мэндийн газар, Эмнэлгийн тусламжийн газрын дарга нартай зөвшилцөн боловсруулж, Зөвлөх хорооны даргаар батлуулан хуралдааны бэлтгэлийг хангах.

4.2 Зөвлөх хорооны хуралдаанаар хэлэлцүүлэх асуудалтай холбогдсон бичиг баримтыг хуралдаан болохоос өмнө 5-аас доошгүй хоногийн өмнө гишүүдэд цахимаар тараах.

4.3 Хуралдааны тэмдэглэл хөтөлж, тэмдэглэлийн хувийг холбогдох хувь байгууллагад хүргүүлэх.

4.4 Зөвлөмж, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах.

4.5 Зөвлөх хорооны архив, бичиг хэргийг хөтлөх.

Эрүүл мэндийн сайдын 2019 оны 03 сарын 26-ны өдрийн 11/34 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралт

“Орон нутгийн иргэдэд түшиглэсэн, уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй ус хангамж, ариун цэвэр, эрүүл ахуйн үйлчилгээ” төслийн зөвлөх хорооны ажиллах журам

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 БНСУ-ын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага, НҮБ-ын Хүүхдийн сангийн хамтарсан санхүүжилттэй Баянхонгор, Говь-Алтай, Завхан аймгуудад 2019-2022 онуудад хэрэгжих “Орон нутгийн иргэдэд түшиглэсэн, уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй ус хангамж, ариун цэвэр, эрүүл ахуйн үйлчилгээ” төслийн зөвлөх хороо /цаашид “Зөвлөх хороо” гэх/-ны үйл ажиллагааг энэхүү журмаар зохицуулна.

1.2 Зөвлөх хороо нь “Орон нутгийн иргэдэд түшиглэсэн, уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй ус хангамж, ариун цэвэр, эрүүл ахуйн үйлчилгээ” төслийн зөвлөх хорооны” төслийн үйл ажиллагааг зохицуулах, хэрэгжүүлэх арга хэмжээний талаар зөвлөмж гарган, санхүүжүүлэгч талд дэмжлэг үзүүлэх орон тооны бус зөвлөх хороо мөн.

1.3 Баянхонгор, Говь-Алтай, Завхан аймгийн Засаг даргын тамгын газрын даргын удирдлага дор уг төслийн хэрэгжилтийг зохицуулах ажлын хэсэг орон нутагт ажиллана.

1.4 Зөвлөх хороо нь Эрүүл мэндийн салбарт хэрэгжиж буй эрхзүйн баримт бичиг, бусад хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгоно.

Хоёр. Зөвлөх хорооны бүтэц, үйл ажиллагааны зохион байгуулалт

2.1 Зөвлөх хороо нь дарга, дэд дарга, нарийн бичгийн дарга болон гишүүдээс бүрдэнэ.

2.2 Зөвлөх хорооны ажлын албаны үүргийг НҮБ-ын Хүүхдийн сан гүйцэтгэнэ.

2.3 Зөвлөх хорооны үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь зөвлөлийн хуралдаан байх ба хуралдааныг Зөвлөх хорооны дарга, түүний эзгүйд дэд дарга зарлан хуралдуулна.

2.4 Зөвлөх хорооны хуралдаан гишүүдийн ердийн олонхийн оролцсоноор хүчин төгөлдөр тооцогдож, асуудлыг хуралдаанд оролцогсдын олонхийн саналаар шийдвэрлэж, дүгнэлт зөвлөмж гаргана. Санал тэнцсэн тохиолдолд асуудлыг хуралдаан даргалагчийн саналаар шийдвэрлэнэ.

2.5 Зөвлөх хорооны гишүүн хүндэтгэх шалтгаангүйгээр хуралдаанд ирэхгүй тохиолдолд шалтгаанаа Зөвлөх хорооны дарга, дэд дарга, нарийн бичгийн дарга нарт хуралдаан болохоос 3 хоногийн өмнө мэдэгдэж, хэлэлцэх асуудалтай холбоотой саналаа ирүүлнэ.

2.6 Зөвлөх хорооны даргын эзгүйд дэд дарга түүнийг орлон ажиллана.

2.7 Зөвлөх хорооны гишүүний эзгүйд түүнийг орлуулахгүй.

2.8 Тухайн хэлэлцэж буй асуудалтай холбоотой ашиг сонирхлын зөрчил үүсэж болзошгүй нөхцөлд хамаарал бүхий гишүүнийг уг асуудлыг хэлэлцэхэд оролцохгүй.

Гурав. Зөвлөх хорооны даргын чиг үүрэг

3.1 Зөвлөх хорооны хуралдааныг жилд хоёроос доошгүй удаа зарлан хуралдуулж, хуралдааныг удирдах.

3.2 Зөвлөх хорооны хуралдааны төлөвлөгөө гаргах.

3.3.Хуралдаанаас гарсан шийдвэрийг тэмдэглэлээр баталгаажуулж, шаардлагатай гэж үзсэн зарим асуудлыг Эрүүл мэндийн яамны Удирдлагын зөвлөлийн хуралд хэлэлцүүлэн чиглэл өгөх.

3.4 Гишүүдэд үүрэг даалгавар өгч, биелэлтэд нь хяналт тавих ба явцын талаар гишүүдэд мэдэгдэх.

Дөрөв. Нарийн бичгийн даргын чиг үүрэг

4.1 Хуралдаанаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг Эрүүл мэндийн яамны Нийгмийн эрүүл мэндийн газар, Эмнэлгийн тусламжийн газрын дарга нартай зөвшилцөн боловсруулж, Зөвлөх хорооны даргаар батлуулан хуралдааны бэлтгэлийг хангах.

4.2 Зөвлөх хорооны хуралдаанаар хэлэлцүүлэх асуудалтай холбогдсон бичиг баримтыг хуралдаан болохоос өмнө 5-аас доошгүй хоногийн өмнө гишүүдэд цахимаар тараах.

4.3 Хуралдааны тэмдэглэл хөтөлж, тэмдэглэлийн хувийг холбогдох хувь байгууллагад хүргүүлэх.

4.4 Зөвлөмж, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах.

4.5 Зөвлөх хорооны архив, бичиг хэргийг хөтлөх.